

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Х.БАТТУЛГЫН АНУ-Д ХИЙСЭН АЙЛЧЛАЛ: АЧ ХОЛБОГДОЛ

A VISIT OF THE PRESIDENT OF MONGOLIA, KH. BATTULGA TO THE U.S.A. AND ITS SIGNIFICANCE

Ц.Алтангэрэл*

***Abstract:** The President of Mongolia, Battulga Khaltmaa paid state visit to the United States aiming to bolster the two countries' political and economic relations into a new strategic partnership. After the meeting between the Mongolian President Kh. Battulga and U.S. President Donald J. Trump, Declaration on the Strategic Partnership between the United States and Mongolia was issued. This declaration indicates Mongolia's successful utilization of the third-neighbor policy and makes the United States the fifth country to establish a strategic partnership with Mongolia. Economic cooperation and economic security were a top priority during Battulga's trip to the United States, and science, technology, and entrepreneurial opportunities were raised during other official meetings. Battulga's state visit also explored cooperation opportunities in space-related projects. Before his White House visit, Kh. Battulga spoke at the Center for Strategic and International Studies' (CSIS) Global Leaders Forum on the future of U.S.-Mongolia relations. The 32 years of diplomatic relations and the newly established strategic partnership between two governments are expected to grow in a very positive direction.*

***Keywords:** President, Mongolia, U.S., third-neighbor, partnership, visit, congress, cashmere, trade, corruption, space, RF, PRC, rare earth element, textile and knitted products*

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд Монгол Улсын улс төрийн гадаад бодлогын нэг хэсэг нь “АНУ, Япон, Европын Холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнийн өндөр хөгжилтэй “гуравдагч хөрш” орнуудтай бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ”² гэж заасан билээ. Монгол Улс уг бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд өндөр хөгжилтэй орнуудтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлж байгаа билээ. Үүний тод илрэл нь манай “гуравдагч хөрш” орнуудын хамгийн хүчирхэг гүрэн

* ШУА-ийн ОУХХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

² Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал

болох АНУ-тай стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх болсон явдал юм. Энэхүү АНУ-тай харилцах харилцаа бол манай улсын хэрэгжүүлж буй “гуравдагч хөрш”-ийн бодлогод суурилсан чухал харилцаа билээ. Энэ харилцаа нь стратегийн нийтлэг эрх ашиг, ардчиллын үнэт зүйлс, сайн засаглал, бүрэн эрхт байдал болон хүний эрхийг дээдлэх зарчмуудад тулгуурлан хөгжиж байна. Энэ талаар АНУ-ын Монгол судлаач, эрдэмтэн Алишиа Кемп:³ “Олон арван жилийн дараа Монгол-АНУ-ын харилцаа маш идэвхитэй үедээ орлоо гэдгийг хоёр тал хүлээн зөвшөөрлөө. Трампын засаг захиргаа өмнөх засаг захиргааг бодвол Энэтхэг Номхон далайн бүс нутагт явуулж буй гадаад бодлогынхоо хүрээнд Монгол Улсыг их боломжтой орон гэж үзэж байгаа юм. Энэ нь Хятад, Орос хоёр хөршөөсөө илүүтэй АНУ-ыг найдвартай түншээ гэж үзэж байгаатай холбоотой” гэсэн байна.

Монгол Улс, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох үйл ажиллагаа “хүйтэн дайн”-ы улмаас ихээхэн саад, бэрхшээлтэй тулгарч байсан бөгөөд бусад өндөр хөгжилтэй капиталист орнуудтай харьцуулахад нилээд хожуу 1987 онд харилцаа тогтоосон юм. Өнгөрсөн 32 жилийн хугацаанд хоёр орны харилцааны түвшин зогсолтгүй ахисаар өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн харилцаанаас стратегийн түншлэлийн шинэ шатанд хүрлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгын АНУ-д 2019 оны 7-р сарын 29-нээс 8-р сарын 3-ны хооронд хийсэн албан ёсны айлчлал нь 2011 оноос хойш “Цагаан ордон”-д хийсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхны айлчлал юм. Трампын засаг захиргааны албаны хүмүүсийн үзэж буйгаар Монгол Улсын гадаад худалдааны 90 орчим хувь нь Хятад улстай, түүгээр дамжин хийгддэг тул Ерөнхийлөгч нарын уулзалтын гол зорилго нь Зүүн Азийн улс орнуудад худалдааны урсгалыг төрөлжүүлэхэд туслах арга замыг судлах явдал байсан⁴ гэжээ. Мөн Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга З. Энхболд: “АНУ-ын айлчлалын гол зорилго нь монголын ноолуур, оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн татваргүй ордог хуулийг дэмжүүлэх байсан. Тэр утгаараа энэ удаагийн айлчлалаар уг хуулийн ач холбогдлыг ерөнхийлөгч Д.Трампад ойлгуулах зорилготой байсан ба Монголын ноолуураар хийсэн оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн яагаад татваргүй орох шаардлагатай вэ гэдгийг тайлбарлахыг зорьсон, тэр амжилттай болсон.”⁵ талаар сонинд өгсөн ярилцлагандаа мэдэгдсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын АНУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр баталсан хамтарсан тунхаглалд хоёр талын харилцаа Стратегийн түншлэлийн түвшинд хүрснийг тунхаглан зарласан юм. Ерөнхийлөгч Х.Баттулгын айлчлалын үеэр АНУ манай улсыг 17 дахь стратегийн түншээрээ сонгосон нь Монгол Улсын нэр хүндийг олон улсын тавцанд өндөрт өргөсөн явдал болсон юм.

³ Алишиа Кемп нь Индиана Их сургуульд Монгол судлалаар докторын зэрэг хамгаалсан бөгөөд 1980-иад оны үеэр Монгол Америкийн хооронд дипломат харилцаа тогтоох ажлыг идэвхижүүлж байсан. Монгол, Хятад, Зүүн хойд Азийн асуудлаар олон арван эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэнээс гадна “20-р зууны Монгол-АНУ-ын улс төрийн харилцаанд дахь Орос, Хятадын нөлөөлөл” томоохон бүтээлийн зохиогч юм.

⁴ Associated Press, News, 2019

⁵ www.dnn.mn 2019.08.13

2018 оны 9 сарын сүүлчээр Ерөнхий сайд У. Хүрэлсүх АНУ-д айлчлах үеэр хоёр тал “Өргөтгөсөн иж бүрэн түншлэл”-ийг тогтоож байсан бол түүнээс хойш жил хүрэхгүй хугацааны дараа манай хоёр орны харилцаа ийнхүү нэг шатаар ахилаа.

Монгол Улс дэлхийн 192 улстай дипломат харилцаа тогтоосон бөгөөд түншлэлийн харилцаатай нийт 10 улс байгаагаас одоо 5 улстай стратегийн түншлэлийн харилцаатай боллоо. АНУ нь тав дахь улс болж байгаа юм. Стратегийн түншлэлийн харилцаатай орнуудыг дараахь хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 1. Стратегийн түншлэлийн харилцаатай улс орнууд⁶

№	Улс	Стратегийн түншлэлийн харилцаа	Эрх зүйн үндэс
1.	БНХАУ	Иж бүрэн стратегийн түншлэл	2014 онд БНХАУ-ын дарга Си Зиньпин манай улсад айлчлах үеэр гаргасан “Хамтарсан тунхаглал”
2.	ОХУ	Иж бүрэн стратегийн түншлэл	2019 оны 9-р сард ОХУ-ын Ерөнхийлөгч В. Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр гаргасан “Хамтарсан тунхаглал”
3.	Япон	Стратегийн түншлэл	2010 онд Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн Японд хийсэн айлчлалын үеэр гаргасан “Хамтарсан мэдэгдэл”
4.	БНЭУ	Стратегийн түншлэл	2015 онд Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Моди манай улсад айлчлах үеэр гаргасан “Хамтарсан мэдэгдэл”
5.	АНУ	Стратегийн түншлэл	2019 оны 8-р сард Ерөнхийлөгч Х.Баттулга АНУ-д хийсэн айлчлалын үеэр гаргасан “Хамтарсан мэдэгдэл”

Монгол Улсын Ерөнхийлөгч Х. Баттулгын АНУ-д хийсэн айлчлал

АНУ-ын Стратеги, олон улс судлалын хүрээлэнд зочилж, үг хэлэв:

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2019 оны 7-р сарын 30-ны өдөр АНУ-ын Стратеги, олон улс судлалын төвд зочилж үг хэлсэн юм. Ерөнхийлөгч Х. Баттулгын хэлсэн үг “хоёр улсын харилцааны түүхэн жим”, “хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны өнөө ба цаашдийн чиглэл” гэсэн хоёр хэсгээс бүрдэж байгаа бөгөөд эхний хэсэгт: “Монгол Улс, АНУ нь 1987 онд албан ёсоор дипломат харилцаа тогтоосон. Харин хоёр улсын иргэд хоорондын харилцаа олон зуун жилийн өмнөөс эхлэлтэй байдаг юм билээ. Монгол Америкийг ойртуулсан түүх 100 гаруй жилийн

⁶ www.mfa.gov

өмнөөс, Америкийн бизнесменүүд, хувь хүмүүс Монголд ирж бизнес, тэр тусмаа хөдөө аж ахуй, уул уурхай салбарыг сонирхож байсан нь өнөө цагт ч ихээхэн өөрчлөгдөөгүй санагдана”⁷ гээд хоёр орны түүхэн замналын тухай өгүүлсэн билээ. Ерөнхийлөгч Х.Баттулгын хэлсэн үгийн хоёрдугаар хэсэгт: Хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны өнөө ба цаашдийн чиглэлийн талаар тусгагдсан бөгөөд батлан хамгаалах салбарт хамтран ажиллаж байгаа талаар ярих. Цааш нь хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа нэн чамлалттай байгааг дурдаад өндөр технологи, хурдацтай шинэчлэлийн энэ цаг үе, орчинд тохируулж эдийн засгийн хамтын ажиллагааны хөрс сууриа сайжруулах ёстой гэж үзэж байгаагаа илэрхийлэв. Тэрээр ноолуурын экспортын бодит нөхцөл байдлыг тайлбарлан ярьж ноолуурынхаа дөнгөж 10 хүрэхгүй хувийг дотооддоо боловсруулж, 90 орчим хувийг нь өмнөд хөрш рүү түүхий эдээр нь буюу хямд өртгөөр экспортолдог гэж хэлсэн үгэндээ цохон тэмдэглэв. Мөн ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь хөдөөгийн иргэдийн аж амьдралыг сайжруулж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлнэ гэдэг талаар ярилаа. Ерөнхийлөгч Х. Баттулга АНУ-ын Конгрессын нэр бүхий гишүүдийн санаачилсан “Туравдагч хөршийн худалдааны хууль”-ийг батална гэдэгт итгэлтэй байгаагаа дурдаад ардчилал, хүний эрх зэрэг нийтлэг үнэт зүйлс дээр тулгуурлан эрчимтэй хөгжсөн улс төрийн харилцааны бат бэх суурин дээр тулгуурлан цаашид хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх нь нэн чухал гэж үзэж байна.

Түүнчлэн “Монгол, Америкийн эдийн засгийн өргөтгөсөн түншлэлийн тухай замын зураглал”, “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай хэлэлцээр” зэрэг баримт бичиг нь эдийн засгийн хамтын ажиллагааны үндсэн суурь нөхцөлийг бүрдүүлдэг тухай ярилаа. АНУ-ын Конгрессоос “Туравдагч хөршийн худалдааны хууль”-ийг батлан гаргавал хоёр талын эдийн засгийн харилцаанд шинэ хуудас нээгдэнэ хэмээн монголчууд хүлээж байна. Ерөнхийлөгч Х. Баттулга ОУСС-ийн хүрээлэнд хэлсэн үгнийхээ сүүлийн хэсэгт гуравдагч хөрш нартайгаа шинжлэх ухаан, өндөр технологи, сансар судлал, цахим эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхийн төлөө ажиллах тухай дурдаад хоёр улсын харилцааны хөгжилд чухал хувь нэмэр оруулж буй эрдэмтэн судлаачид, Монголд элэгтэй америк иргэдэд чин сэтгэлийн талархалаа илэрхийлсэн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х. Баттулга, АНУ-ын Ерөнхийлөгч Д. Трамп нарын уулзалт ба албан ёсны хэлэлцээр:

2019 оны 7-р сарын 31-ны өдөр АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгыг Цагаан ордонд угтан авсан юм. Ерөнхийлөгч нар Цагаан Ордны зууван танхимд ганцаарчилсан уулзалт хийж, дараа нь хамтарсан хэлэлцээр хийж, стратегийн түншлэлийн тунхаглал гаргасан юм. Ерөнхийлөгч Х.Баттулга тус улсад айлчлах үеэрээ АНУ-ын Ерөнхийлөгчийн гэр бүлд морь бэлэглэсэн ба Дональд Трамп бэлэгний мориндоо “Ялалт” хэмээх нэр өгсөн байна.

⁷ www.president.mn

Тэрээр хэлсэн үгэндээ: “Монголчууд их дайчин хүмүүс. Мундаг бөхчүүдтэй, мундаг аваргуудтай. Би Японд очих үеэрээ Монголоос төрсөн сүмогийн дөрвөн их аварга байдаг гэж дуулсан. Энд тэр дөрвөн аваргын нэг нь ирсэн байна” хэмээн онцолжээ. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп нар 7-р сарын 31-ний өдөр Цагаан ордонд албан ёсны хэлэлцээр хийлээ. Хэлэлцээрийн эхэнд АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп Монголын ноолууран бүтээгдэхүүний талаар яриа өрнүүлж, холбогдох албаны хүмүүсдээ үүрэг, чиглэл өгч энэ асуудлаар үргэлжлүүлэн ярилцана гэж хэлсэн байна. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч Х. Баттулга тус хэлэлцээрийн үеэр хоёр улс батлан хамгаалах, соёл, хүмүүнлэгийн салбарт нягт хамтран ажиллаж байгаа хэдий ч худалдааны эргэлт, эдийн засгийн харилцаа муу байгаад онцгойлон анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэж буйгаа илэрхийллээ. Эдийн засгийн харилцааны дээрх асуудлаар хоёр тал үргэлжлүүлэн ярилцахын зэрэгцээ Монгол-АНУ-ын дипломат харилцааны түүхийн талаар халуун дотно яриа өрнүүлж, хэлэлцээрийн төгсгөлд Монгол Улс, АНУ стратегийн түншлэлийн тухай тунхаглал гаргахаар болов.

Монгол Улс, АНУ-ын хооронд байгуулсан хамтарсан тунхаглалын тухай: Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп нарын уулзалтын үр дүнд Монгол Улс, АНУ ойр дотно хамтын ажиллагааны зарчмуудын тухай 2007 оны Тунхаглал, мөн Монгол Улс, АНУ-ын 2004, 2005, 2011 болон 2018 оны Хамтарсан мэдэгдлүүдээр баталгаажуулсан үндсэн зарчмууд нь хоёр талын харилцааг хөгжүүлэх бат бөх үндэс суурь болж буйг нотолж Стратегийн түншлэлийн тунхаглалыг гаргав. Энэхүү тунхаглал нь 8 зүйлээс бүрдэж байгаа бөгөөд хамгийн анхаарал татсан зүйл нь 2, 4 гэж үзэж болно. Өөрөөр хэлвэл Энэтхэг-Номхон далайн бүс нутагт үндэсний аюулгүй байдал, тогтвортой байдлыг буй болгохын төлөө хамтран ажиллана-гэж заасан нь АНУ-аас Энэтхэг-Номхон далай бүс нутагт явуулж стратегийн үйл ажиллагаанд Монгол Улс оролцож хамтран ажиллана-гэсэн үг юм. 4-р зүйлд хоёр орны хооронд худалдаа, хөрөнгө оруулалтыг хөгжүүлэх тухай заасан байна.

“Гуравдагч хөршийн худалдааны хууль /акт/-ийн талаар: АНУ-ын Конгрессын гишүүн Тэд Йохо тэргүүтэй сенатын болон төлөөлөгчийн танхимын нэр бүхий гишүүд 2018 оны 7-р сарын 26-ны өдөр “Гуравдагч хөршийн худалдааны хууль”-ийг хэлэлцүүлэхээр Конгресст өргөн барьсан юм. Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Монголын оёмол, сүлжмэл бүтээгдэхүүнүүдийг АНУ-ын зах зээлд татваргүй экспортлох, Монгол Улс-АНУ-ын хооронд худалдаа хамтын ажиллагаа сайжрах боломж нээгдэхээс гадна оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний салбарт монгол эмэгтэйчүүдийн ажлын байр олноор нэмэгдэнэ. АНУ-ын Конгрессын Төлөөлөгчдийн танхимд хэлэлцүүлэхээр өргөн бариад буй “Гуравдагч хөршийн худалдааны хууль”-ийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга бүрэн дэмжиж, төслийг санаачлагчдад талархлаа илэрхийлсэн юм. 2012 онд хоёр улс нийт 707 сая ам. долларын худалдаа хийж шинэ амжилтыг тогтоож байсан бол 2017 онд Монгол Улс, АНУ-д ердөө 9.4 сая ам.долларын өртөг бүхий бараа, бүтээгдэхүүн

экспортлож, 82.2 сая ам.долларын бараа, бүтээгдэхүүнийг импортолжээ. Энэ нь АНУ-ын импортлож буй бүтээгдэхүүний хэмжээ тус улсаас импортоор оруулж байгаа бараа, бүтээгдэхүүнээс бараг 10 дахин бага байгааг харуулж байна. Ямааны ноолуурын экспорт Монгол Улсын эдийн засагт чухал үүрэгтэй билээ. Монгол Улсын экспортын дийлэнхийг уул уурхайн салбар бүрдүүлдэг бөгөөд удаах нь хөдөө аж ахуйн салбар ордог. Үүн дотроо голлох экспорт нь ноолуур байдаг. АНУ ноолууран бүтээгдэхүүнийхээ ихэнхийг БНХАУ-аас худалдан авдаг. Монголд үйлдвэрлэсэн оёмол, сүлжмэл бүтээгдэхүүнийг АНУ-д татваргүй экспортлох боломжийг олгосноор хоёр улсын худалдааг нэмэгдүүлэх, Монгол Улсын экспорт нэг улс, нэг салбарын бүтээгдэхүүнээс хамаарах хамаарлыг багасгах нөхцөл бүрдэнэ. Ингэснээр Монгол Улсын хувьд эдийн засагт уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх боломжийг бий болгож тогтвортой өсөлтийг хангах юм. Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга З. Энхболд: “Монгол Улсад зориулаад тэр дундаа ноолуур болон оёмол сүлжмэлийн салбарт чөлөөт худалдааны гэрээ байгуулна гэдэг хүндрэлтэй. Тэр утгаараа энэ удаагийн айлчлалаар уг хуулийн ач холбогдлыг ерөнхийлөгч Д.Трампад ойлгуулах гол зорилготой байсан.”⁸ гэж сонинд өгсөн ярилцлагандаа цохон тэмдэглэсэн байна. Мөн айлчлалын бүрэлдхүүнд оролцож явсан Их хурлын гишүүн З. Нарантуяа: “Хэдийгээр ноос, ноолууран оёмол сүлжмэл бүтээгдэхүүн экспортлоно гэж байгаа боловч тодорхой хугацаанд удах магадлалтай. Мөн нэн тэргүүнд хоёр орны харилцааг стратегийн түншлэлийн хэмжээнд хүрсэн гэдгийг зарласан. 1987 онд эхэлсэн дипломат харилцаа маань өнгөрсөн жилүүдэд батлан хамгаалах, хүмүүнлэгийн салбаруудад нэлээд амжилттай хэрэгжиж байсан. Харин энэхүү айлчлалаар эдийн засгийн бодит салбарт харилцан ашигтай худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг шинэ орчин нөхцөлд гаргаж ажиллах боломж бүрдэж байна.” гэж өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн байна. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга хоёр улсын Ерөнхий прокурор нарыг уулзуулж, хамтын ажиллагааг нь эхлүүлсэн бөгөөд энэ нь авлигатай тэмцэх, оффшор болон гадаадад нуусан хөрөнгийг буцаан авчрах тал дээр томоохон алхам хийж байгаа явдал юм. Ингэснээр НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн дагуу бие биедээ туслан ажиллана. Тийнхүү Ерөнхийлөгч Х.Баттулга хоёр улсын хууль тогтоох байгууллагыг хамтран ажиллуулахаар болсон ба авлигал, оффшор дансны асуудалтай тэмцэх эхлэлийг тавьжээ.

Ерөнхийлөгч Х.Баттулга сансар судлалын “NASA” төвд зочилсон нь: Монгол Улсын Ерөнхийлөгч Х. Баттулга айлчлалынхаа үеэр “NASA”-д зочилсон ба үүнтэй холбоотойгоор ОХУ-ын зарим хэвлэлд АНУ нь Монголд бага болон дунд тусгалын пуужин байрлуулах гэж байна гэсэн мэдээлэл гарсан талаар хэвлэл мэдээллийнхэн тамгын газрын даргаас тодруулан асуухад: “Ямар ч утга учиргүй мэдээлэл. Тийм зүйл огт яригдаагүй. Тийм зүйл байж болохгүй. Гадаадын цэргийг оруулах эсэх чинь Үндсэн хуульд байдаг, боломжгүй асуудал, энэ талаар ярих ч боломжгүй. “NASA”-тай уулзсан нь пуужинтай ямар ч холбоогүй.”-гэж хариулжээ. Мөн газрын ховор элémentийг Монгол Улсаас АНУ-д экспортлох талаар асуухад: “Дэлхий дээр

⁸ <https://dnn.mn/author/ariuntsetseg>

БНХАУ-ын дараа орох газрын ховрын нөөцтэй ч гэсэн ашиглалтынхаа технологийн хүндрэлээс болоод одоо хүртэл түүнийгээ ашиглаагүй. Байгаль орчинд хоргүй технологиор ашиглах ёстой шүү дээ. Тийм учраас энэ талаар гарсан мэдээлэлд мөн албан ёсоор няцаалт өгч байна...”-гэж Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга З.Энхболд дээрхи сенсаци дагуулсан асуудлаар байр сууриа илэрхийлжээ. Харин Монгол Улсын говь, цөлд сансрын жуулчдыг бэлтгэх сургалтын төв байгуулах, судалгаа хийх сонирхолтой байгаа тухай яригдсан байна.

Монгол Улс, АНУ-ын харилцаа Стратегийн түншлэлийн хэмжээнд хүрэхтэй холбогдуулан хоёр хөршийн үзэл хандлага:

Хятадын хандлага:

АНУ-ын “Wall Street Journal” сонинд⁹: “Ерөнхийлөгч Трамп Монгол Улсын Ерөнхийлөгч Х. Баттулгыг урьсан гол зорилго нь Трампын засаг захиргаа тухайн бүс нутгийн зохих улс орнуудад эдийн засгийн болон цэргийн тусламж үзүүлэх замаар Хятад, Орост шахалт үзүүлэх оролдлого байсан”-гэж мэдээлжээ. Энэ талаар гарсан мэдээлэлтэй санал нэгтэй байгаагаа Алиши Кемпи бичсэн байна. Хятад Улсын судлаач Сюй Лифаны нийтлэлд, 17 төрлийн газрын ховор химийн элементүүд Дональд Трампын засгийн газрын дипломат стратегийн төлөвлөлтийн анхаарлын төвд байна гэжээ. Түүнчлэн энэхүү нийтлэлд газрын ховор элементийн үнэ цэнэ нь улс төрийн хувьд зайлшгүй байх болно гэдгийг тодорхойлжээ. Ховордсон газрын элементүүд¹⁰ бол орчин үеийн олон тооны технологи, түүний дотор өргөн хэрэглээний цахилгаан хэрэгсэл, компьютер, харилцаа холбоо, эрчим хүч, тээврийн хэрэгсэл, батлан хамгаалах, сансар судлал зэрэг олон салбарт хэрэглэгддэг чухал ач холбогдолтой юм.

2018 онд АНУ-ын Батлан хамгаалах яам АНУ-ын батлан хамгаалах салбар нь Хятад улсын газрын ховор элементүүдээс ихээхэн хамааралтай гэсэн тайланг гаргажээ. 2019 оны 5-р сард Пентагон¹¹ Хятад цэргийн хүч чадлын талаар хийсэн хамгийн сүүлчийн үнэлгээнийхээ тайланд АНУ тэргүүтэй газрын ховор элементийн хангамжийн систем байгуулах саналыг шинэчлэн гаргажээ. Монгол орны ховор элементийн эрдэс баялгийн нөөц 31 сая гаруй тонн байгаа нь Хятадын дараа хоёрдугаарт бичигдэж байна. Хятадын газрын ховор эрдэс баялгын нөөц нь 65.88 сая тонн юм. Ингэснээр манай Монгол улс дэлхийн ховор эрдэс баялгын нөөцийн 16,8%-ийг эзэлж байна гэсэн үг юм.

Гадны шинжээчдийн тодорхойлж байгаагаар “Энэхүү тунхаглал нь улс төрийн шинж чанартай бөгөөд хөрш зэргэлдээ орнуудад чиглэсэн. Монгол бусад улс орнуудын адилаар Хятадын талыг ажиглан харж, түүнтэй болгоомжтой ханддагт

⁹ <https://www.wsj.gov>

¹⁰ Цэвэр ба хэрэглээний химийн олон улсын холбооноос тодорхойлсон газрын ховор элемент (REE) эсвэл газрын ховор метал (REM) нь үечилсэн хүснэгтийн арван долоон химийн элементийн цуглуулга, тухайлбал арван таван лантанид юм. Жишээ нь: скандиум ба йттриум гэх мэт.

¹¹ Пентагон нь АНУ-ын Батлан хамгаалах яамны төв байр, АНУ-ын цэргийн бэлгэдэл болгон Пентагоныг Батлан хамгаалах яам болон түүний удирдлагын нэр томъёо болгон ашигладаг.

байгаа. Өөрөөр ямар нэг өөр тодорхой шалтгаан байгаа юм биш, харин Хятад маш том, хүчирхэг байгаатай холбоотой”¹² гэжээ.

ОХУ-ын хандлага:

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын АНУ-д хийсэн айлчлалын талаар ОХУ-ын хэвлэлд бичихдээ “Бээжинтэй сөргөлдөөнтэй харилцаатай байгаа энэ үед Орос, Хятадын хооронд стратегийн тун чухал байрлалтай Монгол улстай харилцаагаа бэхжүүлэх нь Вашингтоны хувьд чухал юм. Харин Ерөнхийлөгч Х.Баттулгын хувьд Америкт хийж буй айлчлал нь БНХАУ болон ОХУ-тай харилцах харилцаанд тэнцвэрийг хайж байгаа хэрэг¹³” гэжээ. Түүнчлэн Энэтхэг-Номхон далайн бүс нутаг дахь нөхцөл байдлыг хэлэлцэх нь айлчлалын гол зорилгуудын нэг гэж үзэж байгаагаа ОХУ-ын Шинжлэх Ухааны Академийн Алс Дорнодын хүрээлэнгийн захирал Сергей Лузянин онцолсон юм. Түүнчлэн “АНУ, Монгол Улс нь хамтын ажиллагаагаа хөгжүүлэх эрмэлзлэлтэй байдгаа илэрхийлж, терроризм, хар тамхины наймаа, үй олноор хөнөөх зэвсэгийг дэлгэрүүлэх, цахим халдлага, түүнчлэн үндэсний аюулгүй байдал, Энэтхэг-Номхон далайн бүс нутагт тогтвортой байдлыг хангах асуудлын талаар үзэл бодлоо солилцсон байна. Түүнээс гадна талууд худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өндөр түвшинд яриа хэлэлцээ явуулахыг хөхүүлэн дэмжихээ зохих баримт бичгүүдэд цохон мэмдэглсэн байна”- гэж ТАСС-ын мэдээнд дурджээ.¹⁴

ГХЯ-ны Америк, Ойрхи дорнод, Африкийн хэлтэсийн дарга Д.Гансүхээс: -Хоёр хөршийн зүгээс хэрхэн хүлээж авч байгаа бол? гэж сэтгүүлч асуухад: “Нэг их цочирдож хүлээж авахгүй байх аа л гэж бодож байгаа. Учир нь энэ зүйлийг гэнэтхэн очоод байгуулчихсан юм биш. Түүнээс өмнө бид гуравдагч хөршийнхөө орнуудтай тэр дундаа АНУ-тай харилцааны түвшинг ахиулна гэж ярьдаг байсан. Жишээ нь, манай улс гуравдагч хөршүүд Япон, Энэтхэг зэрэг улстай стратегийн түншлэлтэй. Энэтхэг улстай оюун санааны хөршүүд, Японы хувьд шилжилтийн хүнд бэрх цаг үеэс өнөөдрийг хүртэл Монгол Улсад тус дэм болж байна. Манай улс Японтой Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээртэй. Харилцаагаа ийм түвшин аваачсанаар манай улсын гадаад харилцаа тэлж, бидэнд боломж нээгдэж байна л гэж харж байгаа. ОХУ, БНХАУ, АНУ гэсэн дэлхийн том гүрнүүдтэй гурвуулантай нь стратегийн түншийн харилцаа тогтоосон болохоор сонин содон харагдаж байж болох¹⁵” гэжээ. Эдгээр албан ёсны мэдээ, мэдээллээс дүгнэлт хийхэд манай урд, хойд хөршүүд Монгол Улс, АНУ-тай хийж буй Стратегийн түншлэлийг тийм ч их эмзэглэн хүлээн аваагүй гэдэг нь харагдаж байгаа юм.

¹² <https://www.sina.com.cn>

¹³ www.undesten.mn

¹⁴ www.tass.ru

¹⁵ ГХЯ-ны Америк, Ойрхи Дорнод, Африкийн хэлтэсийн дарга Д. Гансүхийн Өдрийн сонинд өгсөн ярилцлагаас

ДҮГНЭЛТ

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын АНУ-д хийсэн айлчлалын гол зорилго нь Стратегийн түншлэлийн тунхаглал байгуулах, Монголын ноолууран оёмол, сүлжмэл бүтээгдхүүнийг АНУ-ын зах зээлд татваргүйгээр экспортлох, манай хоёр орны хооронд хийх худалдааны гол тулгуур эрх зүйн баримт бичиг болох “Монгол-Гуравдагч хөрштэй хийх худалдааны акт”-ыг Конгрессоор батлан гаргуулахын тулд АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампас дэмжлэг туслалцаа авах, түргэвчлүүлэх явдал байлаа. Ингэснээр хоёр орны хооронд олон талын хамтын ажиллагаа удаан хугацаанд хөгжих боломж нээгдэж байгаа юм. Авлигатай тэмцэх, оффшор дансанд буй хууль бус мөнгийг буцааж авчрах боломжийг олох, НҮБ-ын авлигатай тэмцэх конвенцийн дагуу хамтран ажиллах болсон нь энэ айлчлалын ач холбогдолыг илэрхийлэн гаргаж байна. АНУ-ын сансар судлалын төв NASA-гийн захиралтай уулзсан нь сансарын салбарт хоёр орон хамтран ажиллах боломжийг эрэлхийлсэн чухал үйл явдал болжээ. Говьд дунд болон ойрын тусгалын пуужин байршуулах, газрын ховор элементийг АНУ-тай хамтран олзворлох зэрэг асуудал яригдлаа гэсэн мэдээлэл хэвлэл, мэдээлэлийн хэрэгслэлээр цацагдсан ч энэ нь ор үндэсгүй зүйл юм гэж албаны хүмүүс няцаасан нь нийгэмд үүсээд байсан буруу зөв ойлголтуудыг үгүйсгэхэд ач холбогдолтой болсон юм.

НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал
2. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
3. Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, АНУ-ын хоорондын хэлэлцээр
4. Монгол Улс-АНУ-ын өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн тухай Монгол улс, Америкийн Нэгдсэн Улсын хамтарсан мэдэгдэл
5. Гуравдагч хөршийн худалдааны хууль /акт/
6. Д.Золбоо: Ерөнхийлөгч Х.Баттулгын АНУ-д хийсэн ажлын айлчлалын эргэн тойронд ярилцлага, “Зууны мэдээ” сонин, 2019.8.13 №160 (6127)
7. Л.Эрдэнэчулуун: ОХУ-тай тогтоосон иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг ажил хэрэг болгохын тулд хөтөлбөр гаргах нь зөв, Өдрийн сонин, 2019.09.04
8. Alicia campi, US-Mongolian relations during the summer 2019 and the influence of the state visit of President Battulga
9. Agreement on Transparency in Matters Related to International Trade and Investment between the United States of America and Mongolia
10. The Washington Post
11. Associated Press
12. Elizabeth Wishnick, Mongolia: Bridge or Buffer in Northeast Asia?
13. Jonathan Lemire, Zeke Miller and Deb Riechmann; Inside Bolton’s exit: Mongolia, a mustache, a tweet
14. Elliot Silverberg and Matthew Sullivan, “Assessing Trump’s Indo-Pacific Strategy, 2 Years In”

15. З.Нарантуяа: гуравдагч хөршийн худалдааны хуулийг оны өмнө батална гэж найдаж байна, www.dnn.mn
16. Ерөнхийлөгчийн АНУ-д хийсэн айлчлал ба АНУ, Монголын стратегийн түншлэлийн хүрээнд, <https://www.trends.mn/n/9056>
17. Ерөнхийлөгч Х.Баттулгын АНУ-д хийж буй айлчлалыг судлаач ингэж харжээ, www.undesten.mn
18. Дэлхийн ноолуурын зах зээлд гялалзах том боломж хаалга тогшиж байна, www.montsame.mn
19. Bilateral Documents, <https://www.mfa.gov.mn>
20. У.Хүрэлсүх, М.Пэнс нар Монгол, Америкийн харилцаа шат ахиж, өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн түвшинд хүрснийг нотлов, www.dnn.mn
21. The US President Mr. Donald Trump welcomed the President of Mongolia and Mongolian Judo Association President Battulga Khaltmaa to the White House on Wednesday, www.jjf.org
22. Д.Гансүх: Д.Трампа “Х.Баттулга ерөнхийлөгчтэй ярилцсан ноолуурын тухай яриа маш сонирхолтой байлаа” гэж хэлсэн, www.dnn.mn
23. З.Энхболд: АНУ-ын айлчлалын гол зорилго нь монголын ноолуур, оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн татваргүй ордог хуулийг дэмжүүлэх байсан, www.dnn.mn
24. Д.Баярхүү: Монгол улс дэлхийн глобал гүрэн АНУ-тай стратегийн түншлэлд асар богино хугацаанд хүрчихлээ, www.dnn.mn
25. Press Release – Mongolia Third Neighbor Trade Act Introduced to the U.S. Congress, www.montsame.mn
26. Alicia Campi, “The secret of Mongols existence in the world is...”, www.gogo.mn
27. <https://president.mn>
28. <https://www.globalsecurity.org/military/world/mongolia/forrel-us.htm>
29. <http://www.dnnews.com>
30. <https://tass.ru>